



Г.ХОСБАЯР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын
тэнхимийн ахлах багш,
ахмад

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДАД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан хаагчдын дотор хуульд заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг субъект бөгөөд албан хаагчийн эрхийг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалт нь нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх, шийдвэрлэгдвэл зохих тулгамдсан асуудлуудыг хөндөн гаргаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, эрх зүйн байдал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баталгаа, тусламж, дэмжлэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаа, эрх зүйн баталгааг Монгол Улсын “Төрийн албаны тухай”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, холбогдох хууль, эрхийн актаар зохицуулдаг.

Байгууллагын үйл ажиллагааны үр дүн нь албан хаагчдын идэвх санаачилга, ажлын ур чадвар, бүтээлтэй салшгүй холбоотой бөгөөд алба хаагчдын ажлын үр дүн нь тэдний ажиллах баталгааг хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн тусгаж өгснөөс хамаарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах болзол шалгуур холбогдох шаардлагыг хангасан иргэнийг төрийн тусгай албанд авч ажиллуулсаны үндсэн дээр төрийн албан хаагчийн эрх зүйн харилцаа үүсч, албан хаагч нь бүрэн эрхийнхээ дагуу төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, энэхүү харилцааны явцад төрийн захиргааны байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, тэдэнд үзүүлэх тусламж, дэмжлэгээр хангах үүргийг хуулиар хүлээдэг.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг

иргэнийхээ өмнө хариуцна”¹ гэж заасан байдаг.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүмүүнлэг, ардчилсан нийгмийн² үед нийгмийн гишүүн бүр улс орныхоо аль нэг салбарт ажиллаж, хөдөлмөр эрхэлж, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчноор хангуулж, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлж, түүнд тохирсон, амжиргаандаа хүрэлцэхүйц цалин хөлс авч байх нөхцлийг бүрдүүлэх нь төрийн өөрийнх нь үүрэг гэж ойлгож болно. “Эрх зүйт” төр нь хуулийг дээдэлдэг, иргэний нийгмийн хяналтад байдаг, хүний эрх, эрх чөлөөг хангадаг, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлдэг мөн бодитой хамгаалдаг байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдана ажиллана”, мөн зүйлийн 3-т “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”³ хэмээн төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг хэрхэн тогтоох, хангах арга

зам, үүргийг зааж эх сурвалжыг тогтоож өгсөн.

Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1-д “Иргэдэд адил, тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтлана”, 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”⁴ гэж заасан.

Төрийн албан хаагчид тусламж дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалт нь хүний хэрэгцээ шаардлага, эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хангахтай холбоотой төр – төрийн албан хаагчдын хоорондын харилцааг илэрхийлсэн нийгмийн өргөн хүрээтэй асуудал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан хаагчдын дотор хуульд заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг субъект бөгөөд алба хаагчийн эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1

² Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1

³ Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаас төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөн... төрийн албаны янз бүрийн төрөл-тусгай шинжээр тодорхойлогдоно ⁵ гэж онолын хүрээнд тодорхойлсон байна.

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь эрх, үүргийн нийлбэр цогц, хариуцлага болон тэдэнд үзүүлэх тусламж, дэмжлэг бусад бүрэлдэхүүн хэсэг, шинжийг өөртөө багтаасан хэд хэдэн элементүүдийн нарийн төвөгтэй, иж бүрэн төрөл-хэсэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч⁶ тул бусад төрийн

тусгай албан хаагчдын адил нийгмийн хамгаалалд хамрагдаж, нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх эрхээ хангах баталгааг төрөөс шаардах эрхтэй.

Төрийн албан хаагчид үзүүлэх дэмжлэг, тусламжийн товч утгаар тодорхойлон авч үзвэл “хуульчлан тодорхойлсон эрхийг бодитойгоор эдлүүлэх, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, хууль зүйн цогц ойлголт” гэж тодорхойлж болох юм.

Төрийн албан хаагчид үзүүлэх дэмжлэг, тусламж нь төрийн албан тушаал эрхэлж байгаа бүх хүнд нэгэн адил хамааралтай. Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуульд баталгааг зориулалт, шинж байдал, эх үүсвэр, онцлог зэргийг харгалзан цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж гэж төрөлжүүлсэн.

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 27 дугаар зүйлд төрийн албан хаагчийн баталгааг, 28 дугаар зүйлд төрийн албан хаагчийн цалин хөлсийг, 29 дүгээр зүйлд төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөрийг, 30 дугаар зүйлд төрийн албан хаагчид олгох тусламж, 31 дүгээр зүйлд төрийн албан хаагчид олгох шагнал урамшил, 32 дугаар зүйлд төрийн

⁴ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ хот, 2010 он.

⁵ Старилов.Ю.Н. Курс общего административного права. 2002, С 35.

⁶ Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Монгол банкны ерөнхийлөгч, тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний байгууллагын дарга, дипломат албан тушаал, зэвсэг хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч,

мэргэжилтэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, хууль заасан бусад албан тушаал хамааран.

албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг тусган хуульчилсан юм.

Төрийн албан хаагийн эрх зүйн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, 25, 27.2.1, 27.2.2, 27.2.3 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-д “хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах”-аар тусгасан.

Мөн Иргэний хуулийн 498.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэл/-ийн улмаас бусад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана”, мөн хуулийн 498.4-т “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж заасан.

Мөн эдгээр хуулиудаас гадна төрийн тусгай албан хаагчийн хувьд салбар байгууллагын тухай хуулиар давхар эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг заасан. Тухайлбал,

Шүүхийн тухай хуулийн 76-87 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 33-38 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд нийгэм, эдийн засаг, эрх зүйн нэмэгдэл баталгааг заажээ.

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн I дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид “цэргийн албан хаагч” гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”⁷ гэж хуулийн зорилтыг тодорхойлсон бөгөөд “цэргийн албан хаагч”-д хамаарч, нийгмийн хамгааллын тусгай арга хэмжээнд хамрагдах субъект нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч” байхаар хуульчлан тогтоосон байна. Энэхүү хуулиар цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллын арга хэмжээний тогтолцоог:

1. Цэргийн тэтгэвэр:
2. Цэргийн тэтгэмж:

⁷ Төрийн мэдээлэл, 2014, дугаар 9

- хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

- нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж

- нэг удаагийн тэтгэмж

- жирэмсний болон амаржсаны тэтгэмж гэсэн төрөлтэй байдаг.

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн эдийн засаг, нийгмийн эрхийг хангах эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд голлох байр суурийг эзэлдэг эрх зүйн эх сурвалжийн нэг билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй албан хаагч нь Төрийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан нас, ажилласан жилийн шалгуур үзүүлэлтийг хангасны дагуу цэргийн алба хаасны болон цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэвэрт тогтоолгож, хуульд заасны дагуу 18 – 36 сарын нэг удаагийн тэтгэмжийг авдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас сүүлийн 6 жилийн байдлаар нийт 465 албан хаагч тэтгэвэрт гарсан бөгөөд тоон үзүүлэлтээр авч үзвэл 2011 онд 45, 2012 онд 72, 2013 онд 114, 2014 онд 119, 2015 онд 63, 2016 онд 52 албан хаагч тус тус цэргийн алба хаасны болон цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 405 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг баталсан нь Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгосон төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөхөөр заасан байна.

Дэмжлэг, тусалцаа гэдэг ойлголт нь хүн өтлөх, осол гэмтэлд орох, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах, өвчлөх, сурч боловсрох, гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртөх зэргээр хэвийн байдлаар амьдрах нөхцөл алдагдахад төрийн зүгээс тусламж, дэмжлэг үзүүлж буй үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаа бөгөөд нийгмийн хүрээнд эдлэх эрхийг хангахад чиглэгдсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн шинжтэй арга хэмжээний цогц ойлголт юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх тухай ойлголт нь өргөн утгаараа хүний эрхийг хангах, явцуу утгаараа төрийн тусгай албан хаагчийн нарийвчилбал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан

хаагчийн үйл ажиллагаатай уялдаатай яригдах асуудал юм.

Төрийн жинхэнэ албан хаагчид үзүүлэх дэмжлэг тусламж нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид мөн нэгэн адил хамаарах нийтлэг баталгаанаас гадна зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид хамаарах тусгай баталгааг хуулиар тогтоосон байдаг.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулиар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ”⁸ гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь дараах эрх зүйн баталгаа, дэмжлэг, туслалцаагаар хангагддаг.

- Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авах;

- Албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох;

- Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа

түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгох ба хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс авах;

- Жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар байгууллагын зардлаар хооллох;

- Шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон ачаа тээшийг байгууллагын тээврийн хэрэгслээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох;

- Офицер, ахлагч ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох.

- Хорих байгууллагын албан хаагчид үндсэн цалингаас гадна, хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцлийн⁹ болон тусгай албаны, цэргийн цол, зэрэг дэвийн нэмэгдэл

⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он. 132 дугаар зүйлийн 132.1 дэх заалт.

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 189 дүгээр тогтоол.

олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

• Хорих байгууллагад ажилласан хугацааг тооцоход цагдан хорих байр, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан болон сүрьеэг эмчлэх ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, насанд хүрэгсдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр халагдах болон амины сууц барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно гэж хуульчилсан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид үзүүлэх дэмжлэг тусламжийн нэгэн чухал үзүүлэлт болсон юм.

• Мөн Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдах эрхийг эдэлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь:

• Монгол Улсын Үндсэн хууль;
• Монгол Улсын хуулиуд;
(Төрийн албан тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль гэх мэт)

• Хууль эрхийн бусад актууд;
(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан эрхийн актууд)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх тогтолцоог:

1. Цалин хөлс
2. Тэтгэвэр
3. Тэтгэмж
4. Тусламж
5. Нөхөн олговор
6. Хөнгөлөлт, үйлчилгээ
7. Бусад арга хэмжээ гэж бүлэглэн авч үзэж болно.

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 218 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам, 2004 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 112 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад тусламж олгох нөхцөл, журмыг тус тус баталсан.

Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг тогтоосон уг тогтоолд төрийн албанд эргэж орох эрхтэйгээр халагдсан,

хуульд заасан тодорхой үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн захиргааны алба хаагчид, тухайн албан хаагчийн ажиллаж байсан албан тушаалын нэг сарын цалингаас хэтрэхгүй хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байсан байгууллага нь олгохоор заасан байна.

Орон сууцны дэмжлэгийн мөнгөн дүн нь Засгийн газрын 2009 оны 368 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журам”-д заасан төрийн албан хаагчид олгох орон сууцны зээлийн хэмжээтэй адил байхаар тусгажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад үзүүлж буй тусламж дэмжлэг, эрх зүйн баталгааг бусад хууль сахиулах байгууллагуудтай харьцуулан судлахад тухайн байгууллагын чиг үүрэг, онцлогоос шалтгаалан өөр өөр байдлаар тусгагдсан байна.

Эндээс тодорхойлон авч үзвэл эрх зүйн баталгаа гэдэг нь хэм хэмжээг төрөөс тогтоон хуульчилсан, хэрэгжих нөхцөл боломжоор төрийн албадлагаар хамгаалагдсан, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн, зөрчигдсөн тохиолдолд хөндөгдсөн эрх, эрх чөлөөг сэргээн эдлүүлэх боломжийг бүрдүүлсэн заавал биелэгдэх шинжтэй эрх, үүргийн нийлбэр гэж тодорхойлон хэлж болохоор байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдаж нийгмийн олон талт харилцаа, үзэгдлүүд даяарчлагдаж, улам зохион байгуулалттай болж байгаа өнөө үед албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, материаллаг хангамж бэхжээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдийн эрх зүйн баталгаа, түүний дотор тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэх зарим эрх зүйн зохицуулалт хангагдаагүй нь тулгамдаж буй асуудлын нэг билээ.

Монгол Улсын Их хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах”, “ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох” зорилтыг дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх тухай шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн байдлыг хэвээр хадгалж дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг нэмж тусгаж өгсөн байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн болон бусад баталгааг нарийвчлан тусгасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад үзүүлж буй тусламж, дэмжлэгийг боловсронгуй болгоход гарч ирсэн нэгэн том чухал үзүүлэлт болсон гэдэгт судлаачийн зүгээс үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн улс төрийн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглох, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцохыг шаардсан бол татгалзах эрхтэй байхаар заасан. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл,

техник хэрэгсэл ашиглах, алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглохоор тусгасан.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль зүйн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгсөн мэдэгдэл, шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, заавал биелүүлэх ба биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зааж, иргэн, албан тушаалтан хэн боловч шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглохоор заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь албан үүргээ хууль ёсоор гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй бөгөөд алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг Засгийн газар хариуцахаар тогтоосон.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил

тооцож, мөн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахаар болжээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгаанд дараах баталгаануудыг шинээр оруулж өгчээ. Үүнд, Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан мөн Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол тохиолдолд тухайн алба хаагчийн гэр бүлийн нэг гишүүнд түүний сүүлд авч байсан үндсэн цалинг баримтлан 10 жилийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор тусгасан байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмжээс гадна Засгийн газрын нөөц сангаас дараах нөхөх олговор, тусламж олгохоор тусгасан байна.

Үүнд: хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор, хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүүг олгохоор заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагад офицер, ахлагч болон энгийн орон тоонд ажилласан хугацааг тооцоход цагдан хорих байр, хаалттай хорих анги болон сүрьеэг эмчлэх хорих ангид нэг жил ажилласан хугацааг нэг жил гурван сар, нээлттэй хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг, бусад нэгж, сургалт-хүмүүжлийн тусгай болон шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад нэг жил ажилласан хугацааг нэг жил хоёр сар ажилласанд тооцохоор тус тус заасан нь ихээхэн чухал заалт болсон.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эдийн засгийн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл *түүний гэр бүлийг тэргүүн ээлжинд түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах, ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл*

мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгохоор тусгажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжинд, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно. Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгохоор тус тус заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн бусад баталгаанд аймгийн төвөөс бусад суманд томилогдсон шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг шийдвэр гүйцэтгэх

байгууллага хүлээх, аймгийн төвөөс бусад сум, суурин дахь хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт тасралтгүй таван жил ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгохоор заасан нь хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах, тэдний ахуй хангамжинд тодорхой хэмжээнд тусламж, дэмжлэг үзүүлж байгаа томоохон илэрэл гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт ажилласан таван жил тутамд Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдлэхээр тогтоосон байна.

Мөн ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид түүний зөвшөөрснөөр эдлээгүй хоног тутамд үндсэн цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгож болохоор заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид үндсэн цалингаас гадна, ялтан, хоригдогчтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн болон тусгай албаны, цол, зэрэг дэвийн нэмэгдэл олгох ба нэмэгдлийн

хэмжээг Засгийн газар тогтоохоор тусгасан байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа энэхүү үйл явц нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санааны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах, албан хаагчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх, тэдэнд тусламж, дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршиж байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад эрхийн актаар хуульчилсан эрх зүйн баталгаа, албан хаагчид үзүүлэх тусламж, дэмжлэгийг баталгаатай эдлүүлэх эрх зүйн иж бүрэн шинэтгэл хийх шаардлагыг өнөөгийн нийгмийн олон талт харилцаа нөхцөлдүүлж байна. Энэ хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байгаа нь цаг үеэ олсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн хэм хэмжээг тусган өгсөн нь шинэлэг, ололттой тал болжээ.